



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/47

Шивээговь сум

Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын
улсын үзлэг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/82 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг, оношилгоог 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөс 04 дүгээр сарын 29-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Сумын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг, оношилгоог явуулах ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Ж.Батмөнх

(Засаг даргын орлогч дарга)

Нарийн бичгийн дарга:

Д.Өнөржаргал

(Цагдаагийн хэсгийн Хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан зохицуулагч)

Гишүүд:

А.Нандинцэцэг

(1 дүгээр багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

С.Отгонбаатар

(2 дугаар багийн Засаг дарга)

Ё.Батцэнгэл

4212 1 3

(Шивээ-Овоо хувьцаат компанийн
Тээвэр үйлчилгээний хэсгийн
механик)

3. Сумын төвийн албан байгууллага, аж ахуйн нэгж, 1, 2 дугаар багийн иргэдийг хуваарийн дагуу автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг оношилгоонд хамруулж, зохион байгуулж ажиллахыг комиссын дарга /Ж.Батмөнх/- д үүрэг болгосугай.

4. Өөрийн багийн болон байгууллагын эзэмшил, харьяаллын тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж хуваарийн дагуу тооллогод хамруулахыг 1, 2 дугаар багийн Засаг дарга, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ